



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 702

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 769,508,100 (долоон зуун жаран есөн сая таван зуун найман мянга нэг зуун) төгрөг төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэр газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Чинзориг)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Чинзориг)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг сайжруулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Байгууллагад мөрдөгдөж буй улсын төсөвт үйлдвэрийн газрын үеийн дотоод журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэх зэрэг журам, зааврыг төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх;

3.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний дотор үйлдвэрийн газрын эд хөрөнгийг захиран зарцуулж ажиллах;

3.3.Байгууллагын эзэмших эрхийн газрын хэмжээг хашаажуулсан хэмжээгээр баталгаажуулж, өөрчлөлтийг данс бүртгэлд тусгах талаар эрх бүхий байгууллагад хандах;

3.4.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө олж авахыг таслан зогсоож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах;

3.5.Байгууллагын худалдан авах үйл ажиллагааг бүрэн төлөвлөж, үйл ажиллагааг нь сайжруулах, ажилтнуудыг чадавхжуулах, Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.6.Үйлдвэрийн газрын хөдлөх бүрэлдэхүүнд худалдан авах сэлбэг, дагалдах хэрэгсэлд тавигдах шаардлага, тоо хэмжээ, нэр төрлийг нарийвчлан тогтоож тендерийн бичиг баримт боловсруулах, худалдан авалтын төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авах;

3.7.Төрийн өөрийн өмчийн түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлбэл зохих 9,864,000 (есөн сая найман зуун жаран дөрвөн мянган) төгрөгийг 2024 оны 12 дугаар сард багтаан 1009 0000 0703 тоот дансанд төвлөрүүлэх;

3.8.Шалгалтын тайланд дурдсан, үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг эрх бүхий холбогдох байгууллагад танилцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, маргаантай байгаа асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;


3.9.Үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлж ажиллах;

4.Тогтоолын биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
722 дугаар тогтоолын хавсралт

“ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /мян.төг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авч, бүртгэсэн	641,009.1	ТБОНӨТ хуулийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол	Өмчийн асуудлаарх хууль, дүрэм, журмыг зөрчихгүй ажиллах
2	Харуул хамгаалалтын үйлчилгээний арга хэмжээг худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй, тендер шалгаруулалтгүй авсан.	118,635.0	ТБОНӨБАҮХАТ хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”	Арга хэмжээг худалдан авалтын төлөвлөгөөнд бүрэн тусгаж байх
3	Түрээсийн орлого дутуу төвлөрүүлсэн	9,864.0	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол	Зөрчлийг давтан гаргахгүй байх
НИЙТ ДҮН:		769,508,100 (долоон зуун жаран есөн сая таван зуун найман мянга нэг зуун) төгрөг		